



39

**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 51

Номгон

**“Шинэ суурьшлын бүс”-ийн хэсэгчилсэн ерөнхий  
төлөвлөгөөний бүсчлэлд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын “150 мянган айл” орон сууцны хөтөлбөр, “Түрээсийн орон сууц” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, ингэний сүү боловсруулах үйлдвэр, өвөл, зуны хүнсний ногооны зоорь, хүлэмж зэрэг хөнгөн үйлдвэрлэл явуулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “з”, Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн Баянхонгор сумын “Шинэ суурьшлын бүс”-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний сургууль орчмын “Эдлэн газартай нэг айлын сууц”-ны зориулалт бүхий бүсээс 9.48 га талбайг “Нийтийн орон сууцны хорооллын бүс”, “Спорт, амралтын бүс”-ээс 6.0 га талбайг “Хөнгөн үйлдвэрлэлийн бүс” болгон өөрчлөлт оруулан баталсугай.

2. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан тус бүсүүдэд төлөвлөлт хийлгэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Норов/-д үүрэг болгосугай.


ДАРГА  ЭЭНХБАТ



БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНХОНГОР СУМЫН ШИНЭ СУУРШЛЫН БҮСИЙН ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ М1:10000



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны  
04 дүгээр сарын 01-ний өдрийн 51  
дүгээр тогтоолын хавсралт



ТАНИХ ТЭМДЭГ:

	Холимог бүс /Засаг захиргаа, банк, санхүү, худалдаа үйлчилгээ, аочид буудал, соёл урлаг /12.50 га /
	Нийтийн орон сууцны хороолол / 22.1 га /
	Эдэлбэр газартай нэг айлын сууц / 140.6га /
	Таунхаус / 14.6 га /
	Эдэлбэр газаргүй нэг айлын сууц / 7.40 га /
	Сууршлын нөөц бүс / 29.8 га /
	Олон нийтийн үйлчилгээний бүс /Худалдаа үйлчилгээ, аочид буудал, олон нийтийн барилга, байгууламж, оффис / 6.3 га /
	Сургууль, цэцэрлэгийн бүс / 5.4 га /
	Дэд тээ Худалдаа үйлчилгээ / 11.1 га /
	Спорт, амралтын бүс / 10.1 га /
	Соёл, амралт зугаалгын бүс / 18.1 га /
	Хот хоорондын авто замын хамгаалалтын бүс / 25.45 га /
	Авто зам дагуух ногоон зурвас / 12.25 га /
	ШТС, Засвар үйлчилгээний газар / 1.5 га /
	Хөнгөн үйлдвэрийн бүс / 6.0 га /